



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 7/Б1

Улаанбаатар хот

Н.Наранцацралд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, 1.3.3, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Норовын Наранцацрал холбогдох хууль тогтоомж зөрчиж бүртгэл хөтөлсөн нь тус дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 345 дугаар “Дүгнэлт” болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдож байх тул тул түүнд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс “Албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 10 хувиар бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Н.Наранцацралд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Төгс-Эрдэнэ)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл улсын бүртгэгч Н.Наранцацралд тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БОЛДХҮҮ

142500506

5296722 1118266215